

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН
/2022.04.18 - 2022.04.22/

2022.04.22

Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Үйл ажиллагааны гүйцэтгэл
Барилга хот байгуулалтын хэлтэс		
1	Барилгын чиглэл	<ul style="list-style-type: none"> ✓ Засгийн газрын 213-р тогтоолын дагуу барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 3 барилгад олгосон. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын өргөтгөлийн барилга - Орхон сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилга - Дархан сум 10-р баг, Иргэн Д.Бат-Оршихын 90 айлын нийтийн орон сууцны барилга ✓ Захирагчийн ажлын албанд 2022 онд барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон иргэн, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй судалгааг албан бичгээр хүргүүлсэн. ✓ “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ний Төмөртэй толгойн уурхайн хуурай баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах хүсэлт ирүүлсэн боловч барилгын техникийн бичиг баримт дутуу байсан тул албан бичгээр хариуг өгсөн. ✓ 2022.04.16-нд Дархан-Уул аймгийн “Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-2022”, “Дархан барилга экспо-2022” хувийн хэвшилтэй хамтран зохион байгууллаа. Зөвлөгөөнд Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв, аймаг орон нутгийн удирдлагуудыг хамруулсан 60 гаруй төлөөлөл оролцож, салбарын бодлого, хөгжлийн чиг хандлага, хөрөнгө оруулалт, хэрэгжиж буй төсөл хөтөлбөр зэрэг өргөн сэдвийн хүрээнд зөвлөлдөв. “Дархан барилга экспо-2022”-д барилга угсралт, бүтээн байгуулалт, материал үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 26 иргэн, хуулийн этгээд оролцож, иргэдэд орон сууцны үнэ ханш, барилгын материалын мэдээллийг хүргэв.
2	Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Засгийн газрын 212-р тогтоолын дагуу 2 барилгад ашиглалтад оруулах комиссын актыг баталгаажуулж өгсөн. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Дархан сумын 13-р баг үйлдвэрийн раойнд байрлах Эрд хул ХХК-ны 6кВ кабель шугам 160кВ дэд станц - Хонгор сумын төвийн цахилгаан эрчим хүчний 35кВ агаарын шугам, дэд станцын засвар шинэчлэлтийн ажил - Дархан сум 5-р баг Хүслэн төвийн өргөтгөлийн барилгуудад комисс ажилласан. ✓ Дархан-Уул аймгийн хэмжээнд үерийн усны шугам хоолойн зургийг гаргаж Онцгой байдлын газарт хүргүүлсэн.
3	Хот байгуулалтын кадастр, зураг төсөл магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> ✓ Иргэн, аж ахуй нэгж байгууллагын хүсэлтээ Архитектур төлөвлөлтийн 3 даалгавар боловсруулж батлуулав. ✓ Мөн иргэн, аж ахуй нэгж байгууллагын хүсэлтээр 2 байршлын зураг, Ногоон Дархан 2032-ын байршлын зураг, 2 эскиз зургийг тус тус боловсруулж хянаж баталгаажуулсан байна. <p><i>Нэгж талбарын нөхөн бүрдүүлэлтийн буюу нэмэлт ажлын чиглэлээр:</i></p> <ul style="list-style-type: none"> ✓ 80 хүний өргөдлийг нэгж талбартай нь холбож шинэчилсэн бүртгэлд бүрэн хамруулсан. ✓ Өдөр бүр шинэчилсэн бүртгэлд хамрагдахаар ирсэн иргэний мэдээллийг шалгаж, цахим бүртгэлд хамрагдах шаардлагатай 20 иргэний өргөдлийг хүлээн авч мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. ✓ Мөн газар өмчлөөгүй гэсэн лавлагааг 15 иргэнд гаргаж өгч үйлчилсэн.
Газрын удирдлагын хэлтэс		
1	Газрын татвар төлбөр үнэлгээ	<ul style="list-style-type: none"> ✓ 2022.04.20-ны өдөр 4, 5, 7, 8, 9, 11, 12, 13, 14, Өргөө нийт 10 багуудад гараашуудын хаалга, нүүрийг будах, хаягжуулах ажлыг зохион байгуулж хамтран ажиллахыг багийн Засаг дарга нарт уриалан, баг тус бүрийн гараашуудын судалгааг “Гарааш” арга хэмжээний мэдээллийн хамт албан бичгээр хүргүүлсэн.
2	Газрын төлөв байдлын хянан баталгаа,	<ul style="list-style-type: none"> ✓ Захиалгат хянан баталгааны мэдэгдэх хуудас 2 нэгж талбарт үүсгэв. ✓ Захиалгат хянан баталгааны 2 тайлан баталгаажуулж 2 тайланг хянаж буцаасан.

	газрын мониторингийн чиглэл	<ul style="list-style-type: none"> ✓ 31-р хорооллын 376 хувийн хэргийг хөтлөж архивт хүлээлгэн өгөв. /дутуу 43/ ✓ Цахим гэрээ гэрчилгээг 24 нэгж талбарт үүсгэв. <p><i>Нэгж талбарын нөхөн бүрдүүлэлтийн буюу нэмэлт ажлын чиглэлээр:</i></p> <ul style="list-style-type: none"> ✓ Нөхөн бүрдүүлэлт нэг нэгж талбарт хийв. (4505701834) ✓ Өдөр бүр шинэчилсэн бүртгэлд орохоор ирсэн иргэдийн мэдээллийг шалгаж, бүртгэлд орох шаардлагатай иргэдийн нэгж талбарыг олж иргэдэд үйлчилж байна.
Захиргаа аж ахуйн чиглэл		
1	Мэдээллийн технологи, нярав	<p>Мэдээлэл: 70376471 нээлттэй утсаар 15 иргэн, байгууллагын Facebook хуудсанд ирсэн 19 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв.</p> <p>Мэдээлэл технологийн чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Байгууллагын болон сумдын даамлуудын Фэйсбүүк хуудсан дээр Газрын кадастрын системийн нөхөн бүрдүүлэлтийн ажлын талаар тухай бүр 2 шинэ мэдээ оруулав. ✓ Хонгор сумын газрын даамлын компьютерт тохирох үйлдлийн системийн boot бэлтгэж, форматлан үйлдлийн систем, хэрэглээний програмыг суулгаж, төхөөрөмжүүдийг таниулан, VPN-ийн тохиргоог хийв. <p>Нярав:</p> <ul style="list-style-type: none"> ✓ 15 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 53 ширхэгийг хүлээж авч бүртгэв. ✓ Шаардах хуудсаар 1 төрлийн 2 ширхэг бараа материал олгов.

Тайлан боловсруулсан:
Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Золбаясах

Хянасан:

Газрын удирдлагын хэлтсийн дарга

Г.Нямдорж